



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Хүн төвт” ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/019/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 11315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 11315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: СМД аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал: Д.Гэндэнпэлжээ Утас: 99110699 Цахим хаяг: munkhtsatsral@cmdaudit.mn Аудитор: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	1
НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	6
3.1 Залруулсан алдаа	6
3.2 Төлбөрийн акт	6
3.3 Албан шаардлага	7
3.4 Зөвлөмж.....	7
ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	8
4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/	8
4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	8
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	9
Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл	9

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МӨАУМХ	Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбоо
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМС	Эрүүл мэндийн сайд

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 596
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ
ДҮҮРГИЙН ХҮН ТӨВТ ӨЭМТ-ИЙН
ДАРГА Д.ХОРОЛСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хүн төвт ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хүн төвт ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 534.7 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтээр 193.5 сая төгрөгийн, нийт 728.2 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, эрүүл мэндийн ерөнхий газрын санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийсэн байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хүн төвт ӨЭМТ нь Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 534.7 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтээр 193.5 сая төгрөгийн, нийт 728.2 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

1426050513

C:\Users\inarangua\Desktop\Бичиг хэргэ 2026\2026\word\ywsan bichig\DugneIt_2026.docx

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 49 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 98.8 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 97.8 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэх толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. ХӨРӨНГӨ	-	-
1.1 Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,274,344.36	1,452,539.41
1.1.2 Дансны авлага	47,718,337.00	7,761,889.30
1.1.3 Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.6 Бараа материал	19,390,364.78	20,401,666.88
1.1.11 Эргэлтийн хөрөнгийн дүн	70,383,046.14	29,616,095.59
1.2 Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1 Үндсэн хөрөнгө	124,850,906.91	109,575,818.68
1.2.2 Биет бус хөрөнгө	2,340,000.00	140,000.00
1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	127,190,906.91	109,715,818.68
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	197,573,953.05	139,331,914.27
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1 Өр төлбөр	-	-
2.1.1 Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.3 Татварын өр	-	7,536,975.66
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	78,453,857.37	-
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр	-	3,012,000.00
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	78,453,857.37	10,548,975.66
2.1.2 Урт хугацаат өр төлбөр	-	-
2.2 Өр төлбөрийн нийт дүн	78,453,857.37	10,548,975.66
2.3 Эздийн өмч	-	-
2.3.1 Өмч:	19,091,694.75	19,091,694.75
2.3.1.1 төрийн	19,091,694.75	18,381,694.75
2.3.1.2 хувийн	-	710,000.00
2.3.4 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,475,800.00	4,475,800.00
2.3.7 Хуримтлагдсан ашиг	95,552,600.93	105,215,443.86
2.3.9 Эздийн өмчийн дүн	119,120,095.68	128,782,938.61
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	197,573,953.05	139,331,914.27

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. Борлуулалтын орлого (цэвэр)	-	-
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3. Нийт ашиг (алдагдал)	-	-
4. Санхүүжилтийн орлого	696,263,665.17	728,161,433.50
5. Хүүний орлого	63,107.80	87,422.73
6. Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	50,509,910.40	86,066,741.10
8. Бусад орлого	-	4,789,369.32
9. Борлуулалт, маркетингийн зардал	732,129,150.96	809,442,123.72
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	14,707,532.41	9,662,842.93
19. Орлогын татварын зардал	-	-
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	14,707,532.41	9,662,842.93
21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	14,707,532.41	9,662,842.93

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
2. Залруулсан үлдэгдэл	19,091,694.75	4,475,800.00	80,845,068.52	104,412,563.27
3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	14,707,532.41	14,707,532.41
8. Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	19,091,694.75	4,475,800.00	95,552,600.93	119,120,095.68
9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
10. Залруулсан үлдэгдэл	19,091,694.75	4,475,800.00	95,552,600.93	119,120,095.68
11. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	9,662,842.93	9,662,842.93
16. Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/	19,091,694.75	4,475,800.00	105,215,443.86	128,782,938.61

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1 Мөнгөн орлогын дүн	688,113,421.97	772,994,673.25
1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	772,994,673.25
1.1.6 Бусад мөнгөн орлого	688,113,421.97	-
1.2 Мөнгөн зарлагын дүн	674,677,212.49	757,571,428.20
1.2.1 Ажиллагчдад төлсөн	556,158,503.42	645,541,459.87
1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	-
1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	59,117,066.50	31,694,115.15
1.2.9 Бусад мөнгөн зарлага	59,401,642.57	80,335,853.18
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,436,209.48	15,423,245.05
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1 Мөнгөн орлогын дүн	-	-
2.2 Мөнгөн зарлагын дүн	10,189,900.00	17,245,050.00
2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,189,900.00	17,245,050.00
2.3 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10,189,900.00)	(17,245,050.00)
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1 Мөнгөн орлогын дүн	-	-
3.2 Мөнгөн зарлагын дүн	-	-
3.3 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,246,309.48	(1,821,804.95)
5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	28,034.88	3,274,344.36
6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,274,344.36	1,452,539.41

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 500.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулга хийлгэж, баталгаажуулсан. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын өглөгийг 500.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдээдгийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 "Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдээгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх" заалттай зөрчилдөж байгаа бөгөөд санхүүгийн тайлагналын "үнэлгээ ба хуваарилалт", "ангилал", "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой 3,520.8 мянган төгрөгийн 2 зөрчил² илэрснээс 359.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3,161.2 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 1 зөвлөмж өгч, нийцлийн аудиттай холбоотой 45,607.3 мянган төгрөгийн зөрчил илэрч 45,137.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 470.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

Нийт илрүүлсэн 3,520.0 мянган төгрөгийн санхүүгийн тайлагналтай холбоотой зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

3.2 Төлбөрийн акт

- Ажилтанд амралтын нөхөн олговрыг ажилласан цалинтай давхардуулан 359.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалингийн 359.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Биеийн тамир уралдаан тэмцээнд оролцоход зориулан 470.0 мянган төгрөгийг тэмцээний бооцооны хураамжид зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.8-д "Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтыг зөрчсөн байна." заалтад заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Уралдаан тэмцээнд зориулалт бусаар зарцуулсан 470.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.3 Албан шаардлага

- Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 45,137.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" заалтад заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. НББ-ийн тайлагналтай холбоотой асуудал:

Илрүүлэлт-1. Эм боох материалын дансанд 3,161.2 мянган төгрөгийн бусад тусгай зориулалтын багаж, эмнэлгийн хэрэгслийг бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." заалтад заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Толилуулга", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эм боох материалын үлдэгдэлд байгаа 3,161.2 мянган төгрөгийн багаж хэрэгслийг шилжүүлэн бүртгэж, цаашид хууль журамд нийцүүлэн бүртгэлийг ангилж бүртгэх зөвлөмжийг өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг НТАГ-т 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хувь хүний орлогын албан татварын өглөгийг 500.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	500.0	1	500.0			1	500.0				
Дүн	1	500.0	1	500.0	-	-	1	500.0				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажилтанд амралтын нөхөн олговрыг ажилласан цалинтай давхардуулан 359.6 мянган төгрөгийг илүү олгосон байна	1	359.6	1	359.6	-	-		
Эм боох материалын дансанд бусад тусгай зориулалтын багаж, эмнэлгийн хэрэгслийг бүртгэсэн.	1	3,161.2	-	-	-	-	1	3,161.2
Дүн	2	3,520.8	1	359.6			-	3,161.2

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийн 45,137.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн.	1	45,137.3			-	45,137.3	-	-
Тайлант онд 470.0 мянган төгрөгийг уралдаан тэмцээний бооцоонд зориулалт бусаар зарцуулсан.	1	470.0	1	470.0			-	-
Дүн	2	45,607.3	1	470.0	1	45,137.3	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчлөгүү	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт өгсгөсөн	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9
1	ОНӨҮГ		1			1			
	НИЙТ		1			1			



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 05 дугаар сарын 13

№ 121/Б.1770235

Улаанбаатар хот

НТАГ - 2026 /019/ НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хүн Төвт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Амралтын нөхөн олговрыг үндсэн цалинтай давхардуулан 359,640.0 (гурван зуун тавин есөн мянга зургаан зуун дөчин) төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалтад заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон цалингийн 359,640.0 (гурван зуун тавин есөн мянга зургаан зуун дөчин) төгрөгийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хүн Төвт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (Д.Хоролсүрэн), нягтлан бодогч (С.Амаржаргал) нараар төлүүлж Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү торгуулийн орлогын данс MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хүн Төвт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (Д.Хоролсүрэн), нягтлан бодогч (С.Амаржаргал) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"СМД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
А.ЦЭЭНЯМ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110190



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 дугаар сарын 13

№ 122/Б1770235

Улаанбаатар хот

НТАГ-2026/09/НМ-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хүн Төвт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Биеийн тамир уралдаан тэмцээнд оролцоход зориулан 470,000.0 (дөрвөн зуун далан мянган) төгрөгийг тэмцээний бооцооны хураамжид зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.8-д "Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн ТОГТООХ нь:

- Уралдаан тэмцээнд зориулалт бусаар зарцуулсан 470,000.0 (дөрвөн зуун далан мянган) төгрөгийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хүн Төвт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (Д.Хоролсүрэн), нягтлан бодогч (С.Амаржаргал) нараар төлүүлж, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкиндахь НТАГ.хүү торгуулийн орлогын данс MN440090100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хүн Төвт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга (Д.Хоролсүрэн), нягтлан бодогч (С.Амаржаргал) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"СМД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
А.ЦЭЭНЯМ

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426110191



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 200/181770235

Улаанбаатар хот

НТАГ-2026/019/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Хүн Төвт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 45,137,287.0 (дөчин таван сая нэг зуун гучин долоон мянга хоёр зуун наян долоон) төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтыг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүн Төвт Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга Д.Хоролсүрэн, нягтлан бодогч С.Амаржаргал нарт даалгав1,2.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
"СМД АУДИТ" ХХК-ИЙН АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
А.ЦЭЭНЯМ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090456